



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/ЗНБ

Булган сум

Г “Хангинахын шугуйн шагайн тойром” Г
эвент үйл ажиллагааг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9, 13.1.10 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Үндэсний спорт, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Хангинахын шугуйн шагайн тойром”-ын соёл, спортын эвент үйл ажиллагааг 2026 оны 05 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. “Хангинахын шугуйн шагайн тойром” эвент үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай баталсугай.

3. “Хангинахын шугуйн шагайн тойром”-ын эвент үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг ажлын хэсгийн дарга (Д.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

4. Дээрх арга хэмжээнд шаардагдах хөрөнгө болох 18,997,200 (арван найман сая есөн зуун ерэн долоон мянга хоёр зуу) төгрөгийг аймгийн Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

05

Аймгийн Засаг даргын 2026 оны
... дугаар сарын ... ны/ний өдрийн ... дугаар
... дүгээр захирамжийн хавсралт

345

**“ХАНГИНАХЫН ШУГУЙН ТОЙРОМ 2026” ТЭМЦЭЭНИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ШАГНАЛЫН ЗАРДАЛ**

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Хүнс	ш	1	2,440,600	2,440,600
2	Хогийн уут	ш	20	6,000	120,000
3	Бэлтгэгдсэн дүрсэнд хоолойн бичлэг хийлгэх	ш	5	50,000	250,000
4	Бүүст хийлгэх	өдөр	15	17,840	267,600
5	Дизель түлш (евро)	л	80	4,780	382,400
6	Дизель түлш	л	425	4,680	1,989,000
7	АИ-92 бензин	л	330	2,720	897,600
8	Ахуйн газ	л	20	3,500	70,000
9	Өргөмжлөл А3	ш	3	60,000	180,000
10	Өргөмжлөл А4	ш	3	25,000	75,000
11	Медаль	ш	27	15,000	405,000
12	Анонс (хэвлэл)	ш	1	340,000	340,000
13	Ажлын хэсгийн томилолт	хүн	8	60,000	480,000
Нийт дүн					7,897,200
Багийн харвааны шагнал					
15	1-р байр	ш	1	3,000,000	3,000,000
16	2-р байр	ш	1	2,000,000	2,000,000
17	3-р байр	ш	1	1,500,000	1,500,000
18	4-р байр	ш	1	1,000,000	1,000,000
Нийт дүн					7,500,000
Цуваа харвааны шагнал					
19	1-р байр	ш	1	500,000	500,000
20	2-р байр	ш	1	300,000	300,000
21	3-р байр	ш	1	200,000	200,000
Нийт дүн					1,000,000
Нумт харваа					
22	1-р байр	ш	1	1,000,000	1,000,000
23	2-р байр	ш	1	800,000	800,000
24	3-р байр	ш	1	500,000	500,000
25	4-р байр	ш	1	300,000	300,000
Нийт дүн					2,600,000
Нийт дүн					18,997,200

---оОо---